



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/32/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Аудитор 3.Мөнхнасан
Утас: 94115644 Цахим хаяг: Munkhnasanz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.24

№

49

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар ажиллагсдад албан томилолтыг илүү, үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон, цалингийн урьдчилгаа суутгаагүй, төсвөөс төлбөрийн акт төлсөн, анхан шатны баримтгүй хичээл үйлдвэрлэлийн зардлыг зарцуулсан, ирээгүй хөрөнгийг НББ-д бүртгэсэн, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг 57.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

0702000103

Аудитын онцолсон хэсэг

Тус сургууль нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан бол тайлант оны эхний 3 сард тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгаас, сүүлийн саруудын санхүүжилтийг улсын төсвөөс авсан онцлогтой байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12.2 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон. Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэгдэл урамшууллыг олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус сургууль нь 2022 онд нийт нь 770 хүүхэд сургахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 753 хүүхэд сургаж биелэлт 97.8 хувьтай байна.

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 91 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	мянган төгрөгөөр	
	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	99,935.5	178,040.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,064,013.4	6,034,529.6
Нийт хөрөнгийн дүн	6,163,948.9	6,212,569.8
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,155,466.6	6,212,569.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,163,948.9	6,212,569.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,644,048.3	2,216,503.2
Үйл ажиллагааны зардлын дүн	1,811,958.3	2,141,079.9
Үйл ажиллагааны үр дүн	-167,909.9	75,423.2
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	-167,909.9	75,423.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,323,376.6	6,137,146.6
Тайлант оны үр дүн	-167,909.9	75,423.2
Эцсийн үлдэгдэл	6,155,466.6	6,212,569.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,600,893.8	2,010,029.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,596,364.8	1,992,959.5
Үйл ажиллагааны ЦМГ	4,529.0	17,070.1
Хөрөнгө оруулалтын ЦМГ	4,529.0	4,838.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	1,574,481.9	1,574,481.9
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0	0
Урсгал зардал	1,574,481.9	1,574,481.9
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,574,481.9	1,574,481.9
Улсын төсвөөс санхүүжих	1,574,481.9	1,574,481.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,837.7

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74.5 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залрууллаа.

Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхээр 50.8 сая төгрөг шилжүүлж, хүлээн аваагүй хөрөнгийг орлогоор бүртгэснийг залруулж авлагаар тусгасан, мөнгөн гүйлгээний тайланд 1.6 сая төгрөгийн гүйлгээг андууран бүртгэсэн, үр дүнгийн тайланд 3.7 сая төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.
- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Биет бус хөрөнгийн эхний үлдэгдлийг 18.3 сая төгрөгөөр хасаж тайлагнасан нь "УСНББОУС-1, АДБОУС 1250, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-126 MNS-6817-4:2020 стандартын 5.3.1"-ийг зөрчсөн байна.

Аудитаар нийт 57.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 4.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 52.9 сая төгрөгийн зөрчилд 10 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, бүтэц орон тоо шинэчлэн батлаагүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлагыг хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Албан хаагчид 0.03 сая төгрөгийн томилолт илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэсэн заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 3.5 сая төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Сангийн сайдын 2019 оны 190 дугаар тушаалыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажиллагсдаас 0.1 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- ✓ Төсвөөс 0.6 сая төгрөгийн төлбөрийн актыг төлсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Төсвийн хөрөнгөөр 50.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч биетээр ирээгүй нь түүвэрчилсэн тооллогоор илэрсэн, үндсэн хөрөнгийн тооллого зөрүүтэй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан нь, Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд төрийн аудитын байгууллагаас шаардсан баримт материалыг ирүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно".2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх-; хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заалтыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бэлтгэгч, Хоол зүйч Сэтгэл судлаач нарын орон тоо нэмсэн боловч бүтэц орон тоонд оруулж шинэчлэн батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нэгдсэн халаалтад холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль	4	74.6	-	-	4	74.6	4	74.6	-	-	-	-
			-	-					-	-	-	-
Дүн	4	74.6	-	-	4	74.6	4	74.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль	9	57.3	4	4.3	2	-	-	-	1	10	-	-
						-	-	-			-	-
						-	-	-			-	-
Дүн	8	57.3	4	4.3	2	-	-	-	1	10	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	-	-	-	-	1	-	-	-
	НИЙТ					1			